



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018. 10-18 № 45

Асуулга тавих тухай

Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Мах, махан бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, жилд экспортлох хэмжээг 50 мянган тоннд хүргэж, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилт тавьсан. Энэ зорилтоо бүрэн хэрэгжүүлэхэд 2 жилийн хугацаа үлдэж байна.

2000 онд манай улс 30,2 сая толгой малтай байсан бол 2017 оны эцсээр 66,2 сая мал тоологдлоо. 17 жилийн хугацаанд малын тоо 2,2 дахин өссөн боловч малчдын тоо энэ хугацаанд 114 мянгаар буюу 25 хувиар цөөрч, нас нь өндөрсөж, нэг малчинд 72 толгой мал оногдож байснаа 217 толгой болж, ажлын ачаалал нэмэгджээ.

Гэвч малын гаралтай бүтээгдэхүүн ялангуяа махны экспорт өссөнгүй, түүхий эд ноос, ноолуур, арьс ширний үнэ 2015-2016 онд хамгийн доод цэгтээ хүртэл унаж, мал аж ахуйн салбараас улсын эдийн засгийн өсөлтөнд үзүүлэх нөлөө дээшилсэнгүй, малчдын амьжиргаа сайжирсангүй.

Малын тоо жил бүр нэмэгдснээр малчдын байгалийн бэрхшээлийг даан малаа өсгөх чадвар буурч, харин малаасаа хүртэх ашиг орлого нь тэр хэрээр өсч чадахгүй байна. Бэлчээрийн даац хомсдож, цөлжилт нэмэгдэж, байгалийн ургамлын бүтэц алдагдан, усны нөөцийн дутагдалд орох боллоо.

2017 онд манай улс 29,3 мянган тонн мах экспортолж, 54,4 мянган ам. долларын орлого олжээ. Экспортод гаргасан нийт махны 26,1 мянган тонн нь буюу бараг 90 хувь нь адууны мах байгаа дундаж үнэ 1,8 ам. доллар болж, дотоодод борлуулагдаж байгаа махны үнээс доогуур байгаа юм.

Жилд улсын хэмжээнд хүнсэнд хэрэглэж байгаа 8-10 сая толгой малын 30 хүрэхгүй хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд бэлтгэж байгаа бөгөөд тэд хоорондоо нэгдсэн зохион байгуулалт, мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай улмаас ариун цэвэр, эрүүл ахуй, хүнсний стандартын шаардлага хангахуйц мах бэлтгэх боломж муу байна.

Одоогийн байдлаар нийт мал сүргийн 90 хувийг эзэлж байгаа бол малаас 20,0 сая хүртэл толгой малыг экспортод гаргах боломж байгаа бөгөөд ийм нөхцөлд гадаад орнуудын харилцагчидтай махны үнэ, эрүүл мэндийн баталгаа, бэлтгэн нийлүүлэх хугацаа, тээвэрлэх нөхцөл зэрэг гадаад худалдааны өндөр

шаардлага тавигддаг хүнсний хамгийн чухал, эмзэг бүтээгдэхүүнийг бэлтгэн, нийлүүлэх, гадаадад гаргах асуудлыг хариуцсан төрийн өмчийн байгууллагын зохицуулалт зайлшгүй шаардагдаж байна.

Манай улсаас экспортод гаргаж байгаа мал аж ахуйн түүхий эд боловсруулалтгүйгээр гарч, эдийн засгийн ихээхэн боломжоо алдаж байна. Төрийн хэвшлийн аж ахуйн нэгж байгуулснаар малаас гарах бүх төрлийн түүхий эдийг дотооддоо боловсруулах боломж ч бүрдэнэ.

Мал сүргийг өсгөж, энэ салбараас орох үр ашгийг дээшлүүлэх нь зөвхөн малчдын аж амьдралыг дээшлүүлэх төдий асуудал бус, малчдын орлого нэмэгдсэнээр хөдөө орон нутагт улсын төсвөөс санхүүждэг арга хэмжээнүүдийн нэлээд хэсгийг шийдвэрлэх боломж бүрдэнэ, цаашид төвлөрлийг сааруулахад үр дүнгээ өгнө гэж үзэж байна.


Иймд Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13.33 дугаар зүйлийн 33.2-т заасныг үндэслэн Танд хандаж дараах асуулгыг тавьж байна. Үүнд :

1. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд мал, мах бэлтгэлийн тогтолцоог шинээр зохион байгуулах, төрийн өмчийн мах бэлтгэлийн аж ахуйн нэгж байгуулж удирдлага зохион байгуулалтаар хангах талаар
2. Экспортын зориулалтаар мах бэлтгэх үйлдвэр 5-ыг бүсчилэн байгуулах, эдгээр үйлдвэрүүдэд орон нутагт байгуулагдан ажиллаж мах боловсруулах үйлдвэрүүдээс экспортод бэлтгэх махыг нийлүүлэн авч, гадаадын гэрээт улсын стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох боломжийн талаар
3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээ, өөрийн орны нөхцлийг ашиглан энэ онд багтаан нийт малын тоо толгойн 30 хувьд хүрэхээр 20 сая хүртэл толгой малыг экспортод гаргах боломжийг шийдвэрлэх талаар
4. Мал сүргийн бүтцийг алдагдуулахгүйгээр, авч байгаа ашиг шимээ бууруулахгүйгээр тодорхой тооны хязгаарт өсгөн үржүүлэх боломжийг судалж хэрэгжүүлдэг ажлыг гүйцэтгүүлэх талаар тус тус Танд асуулга хүргүүлж байна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их хурлын тухай хуульд заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын тухай хуулийн дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН

ГИШҮҮН



М.БИЛЭГТ

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Ж.МӨНХБАТ